



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

2021 оны 1-р хагас жилийн тайлан



ЭРХЭМ ХҮНДЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА

Юуны өмнө Үндэсний хувьчлалын сан нь 2021 оны 1-р хагас жилд өндөр үр дүнтэй ажилласныг нийт сангийн нэгж эрх эзэмшигчиддээ дуулгахад таатай байна. 2021 оны эхний хагас жилийн хувьд дотоодын хөрөнгийн зах зээл идэвхжиж, Монголын Хөрөнгийн Биржийн Топ 20 индекс бүх цаг үеийн хамгийн өндөр түвшин болох 37973 (оны эхнээс 74% өссөн) түвшинд хүрсэн гайхалтай хагас жил байлаа. Цар тахлын халдвар нэмэгдсэнтэй холбоотойгоор хэд хэдэн удаагийн хатуу хөл хорио тогтоож, бодит эдийн засагт хүндрэл учирсан хэдий ч хөрөнгийн зах зээл огцом өссөн нь зах зээл дээр хүүгийн түвшин буурснаар хадгаламж эзэмшигчид илүү өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг эрэлхийлж эхэлсэнтэй холбоотой байлаа.

2020 онд хувьцааны багцыг 100% дотоодын хувьцаа бүрдүүлж байсан бол 2021 оны 1-р хагас жилд тодорхой хэмжээний гадаад хувьцааг багцад нэмсэн. Гадаад зах зээлийн хувьд цар тахлаас үүдэлтэй тодорхойгүй байдал давамгайлсан хэдий ч сайн компанийн хувьцааг хямд худалдаж авах боломж хэмээн харж ажиллалаа.

Үндэсний хувьчлалын сангийн хувьд 2021 оны 6-р сарын 30-ний өдрийн байдлаар цэвэр хөрөнгийн хэмжээ 7.76 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс 47.8%-иар өссөн буюу жилчилж тооцвол 95.6%-ийн өгөөжтэй ажиллажээ.

Хамтын хаалттай сангийн хувьд нэгж эрхийн арилжааг Монголын Хөрөнгийн Биржээр (МХБ) арилжаалдаг тул сангийн нэгж эрхийн зах зээлийн үнэ нь цэвэр хөрөнгийн үнэлгээнээс зөрүүтэй тогтох нь элбэг тохиолддог. Тэгвэл Үндэсний хувьчлалын сангийн нэгж эрхийн зах зээлийн ханш 6-р сарын 30-ны байдлаар 264.59 хүрч оны эхнээс 143.6%, анх үүсгэн байгуулагдсанаас 165%-иар өссөн байна.

Хөрөнгийн зах зээл тэр дундаа хувьцааны үнэ ханш ирээдүйн хүлээлт дээр үндэслэн богино хугацаанд савладаг. Харин суурь хүчин зүйл, суурь шалтгаан нь дунд болон урт хугацаанд үргэлж ялдаг тул Үндэсний Хувьчлалын Сан нь дунд болон урт хугацааны хөрөнгө оруулалтад төвлөрч ажиллаж байна.

Сангийн менежер

Г.Оргил



ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2021 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ 155.32 төгрөгт хүрч оны эхнээс 48.7% буюу жилчилж тооцвол 95.6%-ийн өгөөжтэй ажиллажээ. Энэ нь сангийн зорилт болох жилийн 17.6%-ийн өгөөжөөс даруй 5.4 дахин өндөр үзүүлэлт юм.
- Бусад хөрөнгө оруулалтын боломжуудтай харьцуулан харвал, Монголын Хөрөнгийн Биржийн Топ20 индекс оны эхнээс 73.7%-ийн өсөлттэй, Монголбанкны бодлогын хүү 6%, Банкуудын шинээр татсан хадгаламжийн хүү жилийн 9.7%, шинээр гарсан Инвескор болон Лэнд бондуудын хүү жилийн 13% болон 14% байна.
- МХБ дээрх Үндэсний Хувьчлалын Сангийн нэгж эрхийн үнэ хагас жилийн эцсийн байдлаар 264.59 хүрч оны эхнээс 143.6% өссөн бөгөөд сангийн нэгж эрхэд ноогдох цэвэр хөрөнгийн үнэлгээнээс 1.7 дахин өндөр үнэтэй байна. Зах зээлийн үнэ нь цэвэр хөрөнгийн үнэлгээнээс өндөр байгаа нь сангийн үр дүн сайн байгаа болон сангийн нэгж эрхийн эзэмшигч болох хүсэл зах зээлд өндөр байгааг харуулж байна.

Хүснэгт 1. Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт (Жилчилж тооцов)

	2019	2020	2020 Н1
Үндэсний Хувьчлалын Сангийн хөрөнгө оруулалтын өгөөж		25.6%	95.6%
ТОП-20-ийн өгөөж	-8.6%	-1.7%	147.5%
Хадгаламжийн хүү	13.5%	11.3%	9.7%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГ НЭГ ХҮСНЭГТЭД ХАРВАЛ

Тикэр

ХОС

Гаргасан нэгж эрх

50 сая ширхэг

Нэгж эрх эзэмшигчийн тоо

6,382

Нэгж эрхийн хаалтын ханш

₮264.59

Зах зээлийн үнэлгээ

₮13.2 тэрбум

Өдрийн дундаж арилжаа

₮44.6 сая

Нэгж эрхийн үнэлгээ (NAV)

₮155.32

Нийт хөрөнгө

₮8.08 тэрбум

Татварын өмнөх ашиг

₮2.83 тэрбум

Хойшлогдсон татварын өр

₮290 сая



САНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сангийн мэдээлэл

“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн эрхтэй, тусгай зориулалтын компани юм

Нэр	“Үндэсний Хувьчлалын Сан” хамтын хөрөнгө оруулалтын сан
Сангийн хэлбэр	Хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан
Үйл ажиллагаа	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх
Хугацаа	Үүсгэн байгуулагдсан хугацаа: 2019-8-7 Үйл ажиллагаа явуулах хугацаа: 10 жил
Сангийн татан төвлөрүүлсэн хөрөнгө	5,000,000,000 төгрөг
Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	“Ард Менежмент ҮЦК” ХХК
Хөрөнгө хадгалах компани	“Голомт Банк” ХХК-ийн кастодиан банкны хэлтэс
Хаяг	Монгол Улс, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн байр, 2 давхар Утас: 976-11-70078080 И-мэйл: info@ardmanagement.mn Вэб сайт: ardmanagement.mn

Сангийн зорилго

Сан нь Монгол Улс болон дэлхий даяар арилжаалагддаг үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийн, түүнээс бий болох ашгийг хөрөнгө оруулагчдадаа хуваарилахаар зорьж ажилладаг. Сангийн зорилго:

- Улс орны эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн өмчит компаниудын хувьчлалд оролцож, компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, үнэлгээг өсгөх замаар урт хугацаанд өгөөж хүртэх;
- Дунд хугацаанд Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьцаа болон бондод хөрөнгө оруулалт хийж, өгөөж хүртэх;
- Мөнгөн урсгал, хөрвөх чадварыг тогтвортой байлгаж, эрсдэлийг багасгахын тулд засгийн газрын үнэт цаас, банкны хадгаламж зэрэг тогтмол орлоготой хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийн өгөөж хүртэх.

Хөрөнгө оруулалтын бодлого

Үндэсний Хувьчлалын Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд сангийн нийт хөрөнгийн 70 хүртэлх хувиар дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж ажилладаг. Ингэхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалт хийдэг болно.



НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Сан нь нийт 2,451 нэгж эрх эзэмшигчтэй байсан бол 2021 оны 1-р хагас жилийн эцэс гэхэд 6382 нэгж эрх эзэмшигчидтэй болж 160 хувиар өссөн байна.


Нэгж эрх эзэмшигчдийн бүтэц

Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
Ард Даатгал ХК	5,735,388	11.5%
А.Тулга	3,000,000	6.0%
Ард Менежмент ҮЦК ХХК	2,500,000	5.0%
М СИ ЭС Инвестмент ХХК	2,500,000	5.0%
Ард Кредит ББСБ ХК	2,338,282	4.7%
Богд Банк ХХК	1,913,428	3.8%
С.Мандахбаяр	1,000,000	2.0%
Г.Наранбат	1,000,000	2.0%
Монре Даатгал ХХК	500,000	1.0%
Ард Бит ХХК	466,269	0.9%
Ард Лайф ХХК	380,436	0.8%
Бусад 6372	28,666,197	57.3%
Нийт	50,000,000	100.0%

Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

САНГИЙН ХАНШИЙН ДИНАМИК

Сангийн нэгж эрхийн зах зээлийн үнэ 2021 оны 4-р сарын 23-ны өдөр хамгийн өндөр түвшин болох 653.89 түвшинд хүрч өссөн нь зах зээл дээр сангийн нэгж эрхийн эрэлт ямар өндөр байсныг харуулж байна. Тухайн үед нэгж эрхэд ногдох сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ нь 179.3 байсан байна. Цэвэр хөрөнгийн үнэ цэнээс 3.6 дахин өндөр үнээр зах зээл дээр арилжаалагдах нь зах зээлийн үнэлгээ хэт өндөр байсныг мөн харуулж байна. Үүнээс 7 хоногийн дараа буюу 4-р сарын 30-ны өдөр сангийн стратегийн хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтаа түгжих хугацаа нь дуусаж, зах зээлд сангийн нэгж эрхийн нийлүүлэлт нэмэгдсэнээр, сангийн зах зээлийн үнэ буурч 250 төгрөг орчимд тогтворжоод байна.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


Хамтын хаалттай сан нь сангийн нэгж эрхийг эргүүлэн худалдаж авдаггүй бөгөөд МХБ дээр гуравдагч этгээдэд худалдах замаар хөрөнгө оруулалтаа мөнгөжүүлэх боломжтой байдаг. Тэгвэл МХБ дээр арилжааны эргэлт өндөр байх нь сангийн нэгж эрхийн хөрвөх чадвар өндөр байгааг илэрхийлж байна. Сангийн нэгж эрхийн арилжааны өдрийн дундаж эргэлт 2020 онд 6.9 сая төгрөг байсан бол 2021 оны 1-р хагас жилд өдрийн дундаж эргэлт нь 44.6 сая төгрөг болж өссөн байна. 2021 оны 1-р хагас жилд сангийн нэгж эрхий арилжааны нийт эргэлт нь 5.5 тэрбум төгрөгт хүрсэнээр МХБ-ийн хамгийн идэвхитэй арилжаалагддаг үнэт цааснуудын нэг болсон байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

Үндэсний хувьчлалын сан нь дотоодын хөрөнгийн захад түлхүү хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд 2021 оны 1-р хагас жилийн эцссийн байдлаар нийт хөрөнгийн 63%-ийг дотоодын хувьцаанд, 9%-ийг гадаад хувьцаанд, 20%-ийг хадгаламжид, үлдсэн хувийг бусад хөрөнгүүдэд байршуулсан байна.


Хөрөнгийн задаргаа



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Хувьцааны багцад нийт 7 секторын хувьцаа байгаа бол багцад эзлэх жингээр Санхүү болон Өргөн хэрэглээний салбарын хувьцаанууд тэргүүлж байна.


Хувьцааны багцын задаргаа



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Хөрөнгө оруулах үйл ажиллагаа нь судалгаа шинжилгээ хийх, зах зээлийн тохиромжтой үеийг хүлээх зэргээр цаг хугацаа ихээр зарцуулдаг үйл ажиллагаа байдаг. Тиймээс Үндэсний хувьчлалын сангийн хувьд хөрөнгийн тодорхой хэсгийг өндөр хүү бүхий хадгаламжид байршуулсан байсан бол 2021 оны 1-р хагас жилд хугацаа нь дууссан хадгаламжийг хувьцаа болон бондод хөрөнгө оруулж ажиллалаа. 2020 оны эцэст хадгаламжийн нийт багцад эзлэх хэмжээ 50% байсан бол 2021 оны 1-р хагас жилийн эцэст нийт багцад эзлэх хадгаламжийн хэмжээ 20% болж буурсан байна. Энэ өөрчлөлт нь хадгаламжийн хүү буурч байгаа, хөрөнгийн зах сэргэж байгаа, хөрөнгийн захад арилжаалагдаж буй өрийн хэрэгслийн нэр төрөл өсөж байгаатай холбоотой байлаа.

Багцын өөрчлөлт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Тайлант хугацаанд нийт 1.6 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийсэн бөгөөд брокерын шимтгэл нь үнийн дүнгийн 0.63%-тай тэнцэж байна. 0.63%-ийн брокерын шимтгэл төлж байгаа нь зах зээлийн жишгээс харьцангуй бага шимтгэл юм.



Сангийн зардал

Тайлант хугацаанд сангийн хөрөнгийн дундаж үлдэгдэл нь 7.35 тэрбум төгрөг байсан бол тухайн хугацаанд гарсан сангийн нийт зардал нь 135.4 сая төгрөг буюу зардлын харьцаа нь 1.84% бөгөөд жилчилж тооцвол 3.69% байна. Харин хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ болон кастодианы үйлчилгээний шимтгэл нь нийлээд жилийн 2.85% буюу Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 28.1-д заасан хязгаарын хүрээнд байна.

Хөрөнгийн задаргаа




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Сангийн эрсдэлийн үнэлгээ

Сангийн эрсдэлийн үнэлгээг сан үүсгэн байгуулагдсан өдрөөс хойших өдөр бүрийн хөдөлгөөний тоон мэдээнд үндэслэн тооцов. Өнгөрсөн хугацааны сангийн эрсдэлийн түвшинг харвал өдрийн стандарт хазайлт 1.5% бөгөөд жилчилж тооцсон стандарт хазайлт нь 24.2% байна. Санхүүгийн зах зээлд эрсдэлийг тооцох нэгж нь стандарт хазайлт (Standard deviation) байдаг бөгөөд стандарт хазайлт нь өндөр байх тусам эрсдэл өндөртэй гэж ойлгодог. Аливаа сан болон хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг харьцуулахдаа зөвхөн өгөөжийг харьцуулбал өрөөсгөл ойлголт болно. Учир нь тухайн өгөөжийг олохын тулд ямар хэмжээний эрсдэл хүлээснийг давхар тооцох хэрэгтэй. Эрсдэлээр жигнэсэн өгөөжийг тооцох хамгийн түгээмэл арга нь Sharpe Ratio бөгөөд уг харьцаа нь 1-с өндөр байх нь сайн үзүүлэлт хэмээн тооцдог. Харин Үндэсний хувьчлалын сангийн Sharpe ratio нь 4.56 байгаа нь дэлхий хэмжээнд өндөр үр дүн гэдгийг дуулгахад таатай байна.

Өдрийн хашийн хөдөлгөөний тархалт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК




2021 ОНЫ 1-р ХАГАС ЖИЛИЙН ДОТООД БОЛОН ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Дэлхийн болон дотоодын хөрөнгийн зах зээлд хоёр дүр зураг зонхилсон хагас жил байлаа. Эхнийх нь улс орнуудын төв банкуудын хэрэгжүүлж буй зөөлөн бодлого болон нам дор хүүгийн түвшин хэрхэн үргэлжлэх вэ? хэзээ зогсох вэ? Нөгөө нь 2020 оноос хойш үргэлжилж буй цар тахлын нөхцөл байдал хэрхэн үргэлжлэх вэ? хэзээ хэвийн нөхцөл байдалд шилжих вэ?

2021 оны гарснаар Монголын хөрөнгийн зах зээл идэвхжиж, өндөр өсөлтийг үзүүлсэн бөгөөд ТОП20 индекс 4-р сард хамгийн дээд түвшин болох 37,973.05 төгрөгт хүрсэн байна. Хөрөнгийн зах идэвхижих гол хүчин зүйл нь хадгаламжийн хүүгийн бууралт болон Ард санхүүгийн нэгдэл бөгөөд түүний охин компаниудын хувьцааны өсөлтийн нөлөө байлаа. 6-р сарын 30-ны өдрийн байдлаар МХБ-ийн ТОП20 индекс 33509.01 түвшинд хүрч хамгийн дээд түвшнээс 11.7%-иар буурсан нь огцом өсөлтийн дараах тохируулгын үе өрнөж байгаа дүр зургийг харуулж байна.

Хөрөнгийн зах зээлийн хөдөлгөөн



Эх сурвалж: Блүүмбэрг


Дэлхийн хөрөнгийн зах зээлийн хөдөлгөөнийг харж болох олон индексүүд байдаг бөгөөд энэ удаад MSCI World индексээс дамжуулан хөрөнгийн зах зээлийн хөдөлгөөнийг харууллаа. MSCI World индекс нь хөгжингүй орнуудын хувьцааг багтаасан индекс бөгөөд нийт зах зээлийн 85%-ийг хамруулсан байдаг тул тохиромжтой индикатор болдог.

Дэлхийн хөрөнгийн захын хувьд савлагаа ихтэй хэдий ч ерөнхий тренд өсөлттэй байна. Цар тахлаас шалтгаалсан хөл хорио суларч, эдийн засаг нээгдэх, хэвийн нөхцөл байдалд шилжих хүлээлт нь хөрөнгийн зах зээлийг дэмжиж байна. Цар

тахлын өдрийн өсөлтийн хэмжээ буурсан, вакцинжуулалт эрчимтэй хийгдэж байгаа зэрэг нь уг хүлээлтийг бодитой болгож байна.


Дэлхий даяар 6-р сарын 30-ны байдлаар Ковид 19 цар тахлаар өвчилсөн нийт хүн амын тоо 182.5 саяд хүрсэн байгаа хэдий ч өдөр бүр илэрч буй өвчлөлийн тоо буурсан байгаа нь сайн үзүүлэлт юм. Мөн дэлхийн хэмжээнд нийт хийгдсэн вакцины тун 3.1 тэрбумд хүрсэн бөгөөд вакцинжуулалтын эрч нэмэгдэж байгааг өдөрт хийгдэж буй вакцины тунгийн өсөлтөөс харж болно.

Дэлхий даяар нэг өдөрт илэрсэн өвчлөлийн тоо





Дэлхийн хэмжээнд нэг өдөрт хийгдэж буй вакцины тун



Эх сурвалж: Блүүмбэрг

Цар тахлын хүнд үеийг даван туулж, дэлхийн улс орнууд хөл хориог сулруулж эхэлснээр эдийн засгийн өндөр өсөлтийг үзүүлж байна. Сөрөг тал нь хэт зөөлөн мөнгөний бодлогоос үүдэлтэй инфляцийн өндөр түвшин, сангийн тэлэх бодлоготой холбоотой түүхий эдийн үнийн өсөлтүүд байна. Эдгээр шалтгаанаас үүдэн зах зээлд хүү өсөх, төсвийн дэмжлэгүүд зогсох хүлээлт үүсээд байгаа нь хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлөх хамгийн том эрсдэл болж байна. АНУ-ын 10 жилийн хугацаатай засгийн газрын бондын өгөөжийг харвал хүү өсөх хүлээлт аль хэдийн эхэлсэн байгааг харж болно.

АНУ-ын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж



Эх сурвалж: Блүүмбэрг

6-р сард болсон АНУ-ын Холбооны нөөцийн банкны хурлын үр дүнгээс харахад бодлогын хүүг өсгөх, цаашлаад мөнгөний нийлүүлэлтийг хумих үйл ажиллагаа эхэлж байгаа дүр зураг ажиглагдав. Гэхдээ инфляцийн өсөлт ямар байхаас ирээдүйн шийдвэрүүд хамаарах болно. Холбооны нөөцийн банкны хувьд жилийн инфляцийн түвшинг 2%-д барих зорилготой байдаг бол 5-р сард, сарын инфляц 0.6%, жилийн инфляц 5%-тай гарсан нь хүлээлтээс өндөр тоон үзүүлэлт байлаа. Гэсэн хэдий ч Холбооны нөөцийн банкнаас одоогийн өндөр инфляцийн түвшин нь түр зуурын үзэгдэл бөгөөд 2022 оноос эхлэн зорилтот 2%-д хүрч буурах учир одоо хэрэгжүүлж буй зөөлөн мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн ажиллах талаар мэдэгдэл хийсэн.

Харин зах зээл энэ өндөр инфляцийг түр хугацааны үзэгдэл үү эсвэл тодорхой хугацаанд үргэлжлэх үзэгдэл үү гэдэг дээр хуваагдсан байдалтай байна. Хэрэв өндөр инфляц нь түр зуурын үзэгдэл бол нийт хөрөнгийн зах зээлд эерэг нөлөөтэй харин эсрэгээрээ бол сөрөг нөлөөг үзүүлэх юм.



2021 ОНЫ 1-р ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(АУДИТЛАГДААГҮЙ)

Санхүүгийн байдлын тайлан

Мян.төг	12/31/2020	6/30/2021
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	998,539.22	235,537.66
Бусад авлага	20,100.11	0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	39,829.94	20,062.85
Бусад эргэлтийн хөрөнгө	2,036,253.97	1,616,095.87
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	2,069,774.69	5,908,180.96
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,164,497.93	7,779,877.34
Бусад эргэлтийн бус хөрөнгө	302,687.39	302,687.39
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	302,687.39	302,687.39
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,467,185.32	8,082,564.73
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Дансны өглөг	223,641.84	19,381.21
Татварын өр	56.78	56.78
Богино хугацаат өр төлбөрийн дүн	223,698.62	19,437.99
Хойшлогдсон татварын өр	22,506.59	296,731.70
Урт хугацаат өр төлбөрийн дүн	22,506.59	296,731.70
Өр төлбөрийн нийт дүн	246,205.21	316,169.69
Өмч-хувийн	5,000,000.00	5,000,000.00
Хуримтлагдсан ашиг	220,980.10	2,766,395.03
Эздийн өмчийн дүн	5,220,980.10	7,766,395.03
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,467,185.32	8,082,564.73

Санхүүгийн байдлын тайлан

Мян.төг	12/31/2020	6/30/2021
Хүүний орлого	66,244.40	121,822.06
Ногдол ашгийн орлого	0	65,989.76
Ерөнхий ба удирдлагын зардал	41,741.81	135,455.42
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0	945.72
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	415.42	67,004.36
Ашиг алдагдалаар дамжуулан БҮЦ-р хэмжсэн санхүүгийн хөрөнгийн БҮЦ-н өсөлтийн олз	225,065.94	2,715,429.83
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	249,983.94	2,835,736.30
Орлогын татварын зардал	29,131.03	290,321.37
Ерөнхий үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	220,852.91	2,545,414.93
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	220,852.91	2,545,414.93



Мөнгөн гүйлгээний тайлан

мян.төг	Тайлант хугацааны дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн	
Мөнгөн зарлагын дүн	93,661.30
Бусад мөнгөн зарлага	93,661.30
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-93,661.30
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн	
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	305,330.13
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	1,812.38
Хүлээн авсан хүүний орлого	49,880.86
Хүлээн авсан ногдол ашиг	65,989.76
Мөнгөн зарлагын дүн	1,081,770.62
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	1,081,758.25
Бусад мөнгөн зарлага	12.38
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-658,757.49
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн	
Бусад мөнгөн орлого	1,350.74
Мөнгөн зарлагын дүн	11,933.50
Бусад мөнгөн зарлага	11,933.50
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-10,582.76
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-763,001.56
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	998,539.22
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	235,537.66



**ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН**